

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК

Дундговь аймаг, Сайнцагаан сум,
7-р баг, Нарлаг

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС”ХК-ий ХЭ-гчдийн ХУРЛЫН ТОГТООЛ

2023.05.08

Дугаар:2023/01

Дундговь аймаг Сайнцагаан сум

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-дэх заалт, 2023 оны 5 сарын 08-ны өдрийн тооллогын комиссын тогтоолыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг баталсугай.
 2. Компанийн 2023 онд хэрэгжүүлэхээр танилцуулсан төлөвлөгөөг үйл ажиллагаандaa хэрэгжүүлэн ажиллахыг шинээр сонгогдсон ТУЗ-д үүрэг болгосугай.
 3. “Мандалговь-Импекс” ХК-ий дүрмийг баталсугай.
 4. “Мандалговь-Импекс” ХК-ий ТУЗ-ийн ердийн гишүүдэд:
 1. Ц.Одгэрэл
 2. О.Мөнх-Эрдэнэ
 3. Д.Одгэрэл
 4. Ю.Отгондэлгэр
 5. С.Амарсанаа
 6. С.Баярцэцэг
- ТУЗ-ийн хараат бус гишүүнд:
1. А.Жавхлан
 2. Д.Алтанчимэг
 3. О.Цэрэннадмид сонгосугай.
5. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.



A handwritten signature in blue ink, appearing to read "S. Bayarczecg".

С.БАЯРЦЭЦЭГ

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК

Дундговь аймаг, Сайнцагаан сум,
7-р баг, Нарлаг

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС”ХК-ий ХЭ-гчдийн ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 2023/01

Хурал хийсэн огноо: **2023.05.08.**

Хурал хийсэн газар: Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7-р баг, Бурд зочид буудлын 2-р давхар
Хурал эхэлсэн хугацаа: **14.00 цаг**

Хурлыг зарлан хуралдуулах болсон тухай мэдээллийг тус ХК-ий ХЭ-гч С.Баярцэцэг мэдээлэл хийв.

Эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилж байна.

С. Баярцэцэг миний бие нь тус ХК-ий 30%-ийн /21410ш/хувьцаа эзэмшигч юм.
“Мандалговь-импекс”ХК-ий 2021.04.26-ны өдрийн ХЭ-гчдийн ээлжит хурлын 0/02 дугаар тогтоол дээр тус ХК-ий ТҮЗ-ийн даргаар Θ.Будхандын нэр албан ёсоор байсан, СЗХ-оос надад ирсэн хариу албан бичиг болон Хөрөнгийн биржийн сайт дээр Θ.Будханд нь ТҮЗ-ийн дарга байгаа талаарх мэдээлэл дээр үндэслэн Θ.Будханд болон ТҮЗ-ийн гишүүдэд 2023.03.04 өдөр хандаж албан ёсоор хүсэлт гаргасан.

- “Компанийн тухай” хуулийн 60,60.1-р зүйлд заасанчлан ХЭ-гчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргахыг,
- Компанийн тухай хуулийн 60-р зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.7, 62.1.9 дэх заалт, 64 дугаар зүйл, 65 дугаар зүйлийн 65.3, 65.4 дэх заалт, 67 дугаар зүйл, санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ийн өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу хурлаа зохион байгуулахыг хүсэж хүсэлтээ явуулсан.

ТҮЗ-өөс хурлын тов зарлах хуулийн хугацаа 2023.03.21 –нд дууссан бөгөөд хамгийн сүүлчийн өдөр буюу 3-р сарын 21-ний өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан Хөрөнгийн бирж, СЗХ-нд хүргэх ёстой. Энэхүү хугацаа нь 3-р сарын 24 өдрөөр дуусгавар болсон бөгөөд энэ хугацаанд ТҮЗ нь хурал хуралдуулах товыг гаргаагүй.

Иймд, Компанийн тухай хуулийн 61.7-д заасан эрхийнхээ дагуу ХЭ-гч С.Баярцэцэг миний бие 3-р сарын 27-ны өдөр ХЭ-гчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж, СЗХ болон ХБиржид зохих бичиг баримтуудыг бүрдүүлэн өгснөөр хуулийн дагуу Хөрөнгийн биржийн вэб сайт дээр тус ХК-ий ХЭ-гчдийн хурлыг зарлан хуралдуулах тов товлогдсон. 2023.05.08 өдөр хуралдааар товлогдонон дагуу хурал зохион байгуулагдаж байна.

С.Баярцэцэг миний бие ээлжит бус хурлын даргаар ажиллана.

Хуралд: ХЭ-гчдээс гадна Ц.Одгэрэл, С.Амарсанаа, Ю.Отгондэлгэр, Ж.Түмэндэлгэр, Б.Нямцэрэн, А.Жавхлан, О.Цэрэннадмид, Д.Алтанчимэг нар хүрэлцэн ирсэн байна.

С.Баярцэцэг: 1. ХЭ-гчдийн хурлын нарийн бичгээр Д.Одгэрэлийг сонгож байна. Д.Одгэрэл Хурлын тэмдэглэлийг хөтөлж ажилдаа орохыг мэдэгдье.

2. Тооллогын комиссыг 2 хүний бүрэлдэхүүнтэй сонгох саналтай байна.

Үүнд: 1. Ж.Түмэндэлгэр

2. Б.Нямцэрэн нарын нэрийг дэвшүүлж байна. Өөр санал байна уу?

Байхгүй бол Тооллогын комиссын даргаар Ж.Түмэндэлгэрийг томилж тооллогын комиссыг ажилдаа орохыг мэдэгдье.

Хурлын ирцийг Ажлын хэсгээс бүртгэсэн хуудсыг Тооллогын комисст өгөв.

ХЭ-гчдийн хурлын ирцийн тухай болон хүчин төгөлдөрт тооцох эсэх тухай танилцуулна уу?

Хурлын ирцийн талаар:

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.1-дэх заалт, 69-р зүйлийн 69.1-дэх заалтыг тус тус үндэслэн **Тооллогын комиссын дарга** Ж.Түмэндэлгэр:

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд 52612 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар оролцож нийт саналын эрх бүхий 71,371 ширхэг энгийн хувьцааны 73,72% болж байгааг хурлын даргад мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалт, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 73,72%-ийг эзэмшигчид хуралд саналын хуудсаа бөглөн оролцсон учир компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай, гэсэн Тооллогын комиссын ТОГТООЛ дугаар 01-ыг уншиж танилцуулав.

С.Баярцэцэг:

Хэлэлцэх асуудал:

“Мандалговь-Импекс” ХК-ий 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх сонсгол, дүгнэлтийг хэлэлцэх
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. ХК-ий дүрмийн төслийг танилцуулан батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүдийн бүрэлдэхүүнийг танилцуулан батлах

Хурлын дэг:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх сонсгол, дүгнэлтийг хэлэлцэх /С.Баярцэцэг 10 мин/
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах /С.Баярцэцэг 3 мин/
3. ХК-ий дүрмийн төслийг танилцуулан батлах /Д.Одгэрэл 10 мин/
4. ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүдийн бүрэлдэхүүнийг танилцуулан батлах /Д.Одгэрэл 10 мин/
5. Санал, шүүмжлэл /хүн тус бүр 2 мин/
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулах

С.Баярцэцэг 1 мин

Хурлын явц:

1. Хэлэлцэх асуудлыг танилцуулж 100% саналаар батлав.
2. Хурлын дотоод журам, дэгийг танилцуулахад, санал нэгтгэйгээр батлав. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, саналаа тухай бүр гаргахаар шийдвэрлэв.
3. Хурлын дэгийн дагуу:

Нэг: Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх сонсгол, дүгнэлтийг С.Баярцэцэг танилцуулав.

С.Баярцэцэг: Тайлантай холбоотойгоор асуух асуулт байна уу?

О.Мөнх-Эрдэнэ: Энэ санхүүгийн тайлангийн аудитын компанийг хэн сонгосон юм.

Д.Одгэрэл: Өмнөх удирдлага болох Уранбайгал 2022 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Төгсгүүд консалтинг аудит” ХХК-аар хийлгэж бидэнд илгээсэн. Түүн дээр үндэслэж 2022 оны үйл ажиллагааны тайланг гаргасан.

С.Баярцэцэг: Өөр асуух асуулт байна уу. Байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалд ороё.

Хоёр: Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө С.Баярцэцэг танилцуулав.

С.Баярцэцэг: Төлөвлөгөөнд тусгах өөр санал байна уу?

О.Мөнх-Эрдэнэ: Барилга болон газрын өмчлөлийн талаарх түүхийг Улсын бүртгэлийн газраас авах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнийг 2023 онд компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулж өгье.

С.Баярцэцэг: Улсын бүртгэлийн газраас Мандалговь-импекс ХК-ийн нэр дээр байгаа үл хөдлөх хөрөнгийн талаарх түүхийг өөрийн компанийн албан бичгээр хүсэлт гаргаж лавлагаа, тодорхойлолт авч, Үндсэн хөрөнгийг баримтанд тулгуурлан балансанд бүртгэх хэрэгтэй.

О.Мөнх-Эрдэнэ: Дэмжиж байна.

С.Баярцэцэг: Өөр санал байхгүй бол 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд дээрх ажлыг тусгая.

Гурав: ХК-ий дүрмийн төслийг Д.Одгэрэл танилцуулав.

О.Мөнх-Эрдэнэ: ТУЗ-н гишүүдэд нэр дэвшиж байгаа хүмүүс зарим нь Улаанбаатар хотод, зарим нь Дундговь аймагтаа ажиллаж амьдардаг хүмүүс байна. Иймд үргэлж нэр дороо цуглаж хуралдаад цаг хугацаа болон гарах зардлыг бодолцож гишүүдийг хуралд оролцож боломжийг олгох үүднээс ТУЗ-ын хурлаа цахим хэлбэрээр явуулах тухай дүрмэнд тусгая. Ийм дүрмийн төслийн 7.33-р зүйлд нэмж тусгах саналтай байна.

С.Баярцэцэг: Санал нэг байна. Дүрмийн “7.33. ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.” гэснийг “7.33. ТУЗ-ийн хурлыг сард нэг удаа цахимаар хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.” гэж оруулья.

Дүрмийн төсөлтэй холбоотой өөр санал байна уу.

Д.Одгэрэл: Байхгүй

- Тооллогын комисс тус ХК-ий ХЭ-гчдийн ээлжит бус хуралд санал авах хуудсыг тарааж өгнө үү.
Санал өгөх хуудас дээр ХЭ-гч та бүхэн саналаа өгч бөглөнө.
- Тооллогын комисс Санал авах хуудсыг хураан авч Саналын дүнг танилцуулав.
Тооллогын комиссын ТОГТООЛ дугаар 02-ыг танилцуулав.

Дөрөв: ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүдийн бүрэлдэхүүнийг Д.Одгэрэл танилцуулав.

ТУЗ-ийн ердийн гишүүдэд:

1. Ц.Одгэрэл
2. О.Мөнх-Эрдэнэ
3. Д.Одгэрэл
4. Ю.Отгондэлгэр
5. С.Амарсанаа
6. С.Баярцэцэг

ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

1. А.Жавхлан
2. Д.Алтанчимэг
3. О.Цэрэннадмид Эдгээр хүмүүсийн нэрийг дэвшүүлж байна.

- Тооллогын комисс тус ХК-ий ХЭ-гчдийн ээлжит бус хуралд санал авах хуудсыг тарааж өгнө үү.
Санал өгөх хуудас дээр ХЭ-гч та бүхэн саналаа өгч бөглөнө.

Д.Одгэрэл: ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүдийн бүрэлдэхүүнд өөр нэр дэвшүүлэх санал байна уу?/ санал авах хуудас дээр дээрхээс өөр нэмж нэр бичүүлэх санал байна уу?

Байхгүй

- Тооллогын комисс тоолж, саналын дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын Тогтоол дугаар 03-ыг танилцуулав. ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүдийг саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 73,72% нь зөвшөөрсөн байна.

Тав: Санал, шүүмжлэл /хүн тус бүр 2 мин/

О.Мөнх-Эрдэнэ: Шинэ томилогдсон ТУЗ-ын гишүүдэд баяр хүргэе.

Зургаа: Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-дэх заалт, 2023 оны 5 сарын 08-ны өдрийн ТООЛЛОГЫН КОМИССЫН тогтоолыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2023 онд хэрэгжүүлэхээр танилцуулсан төлөвлөгөөг үйл ажиллагаандaa хэрэгжүүлэн ажиллахыг шинээр сонгогдсон ТУЗ-д үүрэг болгосугай.
3. "Мандалговь-Импекс" ХК-ий дүрмийг баталсугай.
4. "Мандалговь-Импекс" ХК-ий ТУЗ-ийн ердийн гишүүдэд:
 1. Ц.Одгэрэл
 2. О.Мөнх-Эрдэнэ
 3. Д.Одгэрэл
 4. Ю.Отгондэлгэр
 5. С.Амарсанаа
 6. С.Баярцэцэг

ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

1. А.Жавхлан
 2. Д.Алтанчимэг
 3. О.Цэрэннадмид сонгосугай.
5. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ:

ХЭ-гч

ХЭ-гч

ХЭ-гч

O. Mönch-Erdene
S. Bayarczæg
D.Odgäre

О.Мөнх-Эрдэнэ

С.Баярцэцэг

Д.Одгэрэл

Тэмдэглэл хөтөлсөн:

Д.Одгэрэл

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК

Дундговь аймаг, Сайнцагаан сум,
7-р баг, Нарлаг

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС”ХК-ий ХЭ-гчдийн ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023.05.08

Дугаар:2023/01

Дундговь аймаг Сайнцагаан сум

XЭ-гчдийн хурлын ирцийг танилцуулах тухай

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.1-дэх заалт, 69-р зүйлийн 69.1-дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит бус хуралд 52612 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар оролцож нийт саналын эрх бүхий 71,371 ширхэг энгийн хувьцааны 73,72% болж байгааг хурлын даргад мэдээлсүгэй.
- Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалт, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 73,72% -ийг эзэмшигчид хуралд саналын хуудсаа бөглөн оролцсон учир компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Тооллогын комиссын дарга



Ж.Түмэндэлгэр

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК

Дундговь аймаг, Сайнцагаан сум,
7-р баг, Нарлаг

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС”ХК-ий ХЭ-гчдийн ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023.05.08

Дугаар:2023/02

Дундговь аймаг Сайнцагаан сум

ТАЙЛАН, ТӨЛӨВЛӨГӨӨ, ДУРМИЙН ТАЛААРХ САНАЛЫН ХУУДАСНЫ ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-дэх заалт, 2023 оны 5 сарын 08-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын ДҮНГ танилцуулан **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт

САНАЛ АВАХ ХУУДАС	Тоо	Хувь
Санал өгөх хувьцааны тоо:	52,612	73,72%
Зөвшөөрсөн	52,612	73,72%
Татгалзсан		
Тутгэлзсэн		

2. Компанийн 2023 онд хэрэгжүүлэхээр танилцуулсан төлөвлөгөө

САНАЛ АВАХ ХУУДАС	Тоо	Хувь
Санал өгөх хувьцааны тоо:	52,612	73,72%
Зөвшөөрсөн	52,612	73,72%
Татгалзсан		
Тутгэлзсэн		

3. “Мандалговь-Импекс” ХК-ий дүрэм

САНАЛ АВАХ ХУУДАС	Тоо	Хувь
Санал өгөх хувьцааны тоо:	52,612	73,72%
Зөвшөөрсөн	52,612	73,72%
Татгалзсан		
Тутгэлзсэн		



Ж.Түмэндэлгэр

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК

Дундговь аймаг, Сайнцагаан сум,
7-р баг, Нарлаг

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС”ХК-ий ХЭ-гчдийн ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2023.05.08

Дугаар:2023/03

Дундговь аймаг Сайнцагаан сум

**Компаний төлөөлөн удирдах зөвлөлийн
Ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 заалт, 2023 оны 5-р сарын 08-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

Нэг. ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшсэн хүн тус бүрээр тоолсон саналын дүн:

1. Ц.Одгэрэл -52,612 санал буюу 73,72%
2. О.Мөнх-Эрдэнэ -52,612 санал буюу 73,72%
3. Д.Одгэрэл -52,612 санал буюу 73,72%
4. Ю.Отгондэлгэр -52,612 санал буюу 73,72%
5. С.Амарсанаа -52,612 санал буюу 73,72%
6. С.Баярцэцэг -52,612 санал буюу 73,72%

Хоёр. ТУЗ-ийн хараат бус гишүүнд: нэр дэвшсэн хүн тус бүрээр тоолсон саналын дун:

7. А.Жавхлан -52,612 санал буюу 73,72%
8. Д.Алтанчимэг -52,612 санал буюу 73,72%
9. О.Цэрэннадмид - 52,612 санал буюу 73,72%

Тооллогын комиссын дарга



Ж.Түмэндэлгэр